**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр Дугаар А/123 Бор-Өндөр сум

Өмчлөлийн газрын байршлыг
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмчлөлийн газрын байршлыг тодорхой шалтгааны (үер ус урсдаг, жалгатай) улмаас өөрчлөх хүсэлт ирүүлж, холбогдох баримт матералыг бүрдүүлсэн иргэдэд Нэгдүгээр хавсралтад заасны дагуу сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаар газрын байршлыг нь өөрчилсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбоотой нэгдүгээр хавсралтад дурдсан өмнөх газрын мэдээллийн санд бүртгэгдсэн хэсгүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, газрын мэдээллийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ

Сумын Засаг даргын 2024 оны 06-р сарын 27-ны өдрийн А/123-р захирамжийн нэгдүгээр хавсралт

## Газар өмчлөгч иргэдийн мэдээлэл

| д/д | Өмчлөгчийн | | | | Хамтран өмчлөгч | | | | Өмнөх захирамжийн | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Эцэг эхийн нэр | Нэр | Регистр | | | | | Огноо | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар |
| 1 | Боржигин | Суворов | Батжаргал | ЕА81042019 | | | | | 2009.06.22 | 54 | 1 | 11 |
| 2 | Мэргэд | Рэнцэн | Цэцэгсүрэн | С358061111 | Боржигин | Хандсүрэн | Дархи | С359082605 | 2008.01.12 | 3 | 4 | 29 |
| | | | | | Мэргэд | Цэцэгсүрэн | Батцэцэг | С395030307 | | | | |

Сумын Засаг даргын 2024 оны 06-р
сарын 27-ны өдрийн А/423-р
захирамжийн нэгдүгээр хавсралт

| д/д | Өмнөх газрын | | Батлагдсан газрын | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэгж талбарын дугаар | Хаяг | Хэмжээ /мкв/ | Байршил | Ашиглалтын зориулалт | Үнэ /төгрөг/ |
| 0 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 4 | 2322002223 | 4-р баг,Геологи-2 гудамж, 209 тоот | 700 | 4-р баг Уурхайчин, Шинэ суурьшил-1 гудамж, 101 тоот | Гэр бүлийн хэрэгцээ | 2100000 |
| 5 | 221000871 | 4-р баг,Геологи-2 гудамж, 216 тоот | 700 | 4-р баг Уурхайчин, Шинэ суурьшил-1 гудамж, 103а тоот | Гэр бүлийн хэрэгцээ | 2100000 |
| Нийт | | | | | | |